



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 4/151

Булган сум

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Аймгийн Шүүхийн тамгын газрын албан хэрэгцээний автомашин” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны
газрын дарга)

Гишүүд: М.Долгор (Шүүхийн тамгын газрын шүүгчийн
туслах)

Г.Дэлгэр (Худалдан авах ажиллагааны
газрын мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл: Б.Туяа (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: А.Гэрэл (Худалдан авах ажиллагааны
газрын мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР



6325010195